

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН
2018 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 09 дүгээр сарын 25

Чойбалсан хот

Арга хэмжээ /гарц/-ийн шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ийн хүрэх түвшинь	Жинхэнэ гүйцэтгэл /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/	Үнэлгээ /нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо/
1	2	3
<p>1.1.1. Орон нутгийн төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудаас зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, сургалтанд оролцох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Байгууллагын үндсэн чиг үүргийг талаар үнэн зөв ойлголттой болсон байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн газрын дарга Дорнод аймгийн “Удирдах ажилтны шуурхай хуралдаан”-д 3 удаа сууж бүсийн газартаа 2 удаа хурал зохион байгуулсан. Мөн Хэнтий аймаг дахь ахлах мэргэжилтэн, Сүхбаатар аймаг дахь хэлтсийн дарга нар тус аймгийнхаа удирдах ажилтны шуурхай хуралдаанд байгууллага төлөөлөн сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажилласан байна. 9 дүгээр сарын 7-ны өдөр Чойбалсан нисэх буудлаас зохион байгуулсан “Аюулгүй байдлын” хуралдаанд Бүсийн газрын дарга оролцсон. Сүхбаатар аймаг дахь хэлтэс тус аймгийн Засаг даргын 2018 оны Д/477 тоот захирамжийн хүрээнд 9 дүгээр сарын 20-ноос 28-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-танд хамрагдан гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байна.</p>	
<p>1.1.2. Нутгийн захиргааны болон хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль тогтоомжийн талаар нэг мөр ойлголт өгөх Хугацаа: Сардаа</p>	<p>Хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын Цагдаагийн газар, Тагнуулын газар, Прокурорын газар болон аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэст тус тус 9 дүгээр сарын зөрчил шалган шийдвэрлэсэн талаарх мэдээг гадаадын иргэдийн тоон мэдээллийн хамт хүргүүлж хамтран ажилласан.</p>	
<p>1.2.1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам”-ын хэрэгжилтийг ханган, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллах, үр дүнг тайлагнах</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолоор өгсөн Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай үүргийг Зүүн бүс дэх газрын нийт албан хаагчдад шуурхай хуралдаанд уншиж танилцуулсан. Үүргийг хэрэгжүүлэх үүднээс албан хаагчдад дотоод сүлжээгээр 9 дүгээр сарын 10-ны өдөр албан үүрэг өгч Хэнтий аймгийн Тамгын дарга, Ульхан, Эрээнцав боомтын эрхлэгч, Дорнод</p>	

<p>Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны үр дүн гарсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>аймгийн ЭМГ-н дарга нарт хамтын ажиллагааны талаар албан бичиг хүргүүлсэн. Мөн Бүсийн газрын дарга, ахлах нягтлан бодогч нар Тамгын газрын даргаар 17/01-2018011 тоот “Хилийн боомт орон нутагт ажиллах тухай” удирдамжийг батлуулан Ульхан, Эрэнцав, Хавирга, Баянхошуу, Сүмбэр боомтуудад Засгийн газрын 258 дугаар тогтоолын хэрэгжилт болон өвлийн бэлтгэл ажлын хүрээнд дотоод шалгалт хийн ажилласан.</p>	
<p>2.1.1. Монгол Улсад цагаачлан оршин сууж байгаа гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт болон иргэний харьяаллын асуудлаар гаргасан бусад хүсэлтийг хүлээн авч зөвлөгөө өгөх, хүлээн авсан баримт бичгийн бүрдлийг Харьяатын газарт хүргүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хүсэлт гаргаагүй</p>	
<p>3.1.1. Гадаадын иргэнд Монгол Улсын энгийн зэргийн виз олгох, хугацаа сунгах, визийн зөвшөөрөл хүссэн тухай Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бүсийн боомтод 1 удаагийн “орох” зориулалтын визийн зөвшөөрөл авах хүсэлт гаргасан 1 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, материалын бүрдлийг ханган Виз, зөвшөөрлийн газарт хүргүүлсэн.</p>	
<p>3.1.2. Монгол Улсад зорчих хувийн урилга олгох Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тус сард гадаадын иргэнийг урих хүсэлт ирээгүй.</p>	
<p>3.1.3. Оршин суух зөвшөөрөл, хугацаа сунгах, хасах, оршин суух үнэмлэх авах, өөрчлөлт бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авах, хянах хүсэлтийг хүлээн авч Виз, зөвшөөрлийн газарт уламжлан шийдвэрлүүлэх</p>	<p>Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 4 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу НГ ангиллын орох визээр орж ирсэн БНХАУ-ын 35 иргэн, визийн сунгалт хийлгэсэн 4 иргэнийг түр ирэгчээр бүртгэсэн. Мөн зөрчил гаргасан 1 иргэнийг түр ирэгчээр бүртгэж, хасалт хийсэн байна. /Түр ирэгч бүртгэл-40, хасалт-16/</p>	

<p>Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>1 аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу нийт 15 иргэний НГ ангиллын оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн. /ОСЗ хасалт нийт-15/</p>	
<p>3.1.4. Монгол Улсад түр ирэгч гадаадын иргэнийг бүртгэх, хасах, түүнчлэн хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэнийг бүртгэх, хасах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Бичигт, Сүмбэр, Баянхошуу, Хавирга боомтуудаар ХОНДЗҮ-ээр зорчсон БНХАУ-ын 252 иргэнийг бүртгэн, 233 иргэнд хасалт хийсэн.</p>	
<p>3.1.5. Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суухаар анх удаа ирсэн гадаадын иргэний хурууны хээ бусад мэдээллийг журмын дагуу авч нэгдсэн санд оруулах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Төрийн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэсэн байна Хугацаа: Сардаа</p>	<p>Монгол Улсад анх удаа оршин суухаар ирсэн БНХАУ-н 46 иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан байна. Үүнээс Бичигт боомт 4 иргэний, Бүсийн төвд 42 иргэний зураг хурууны хээг авч нэгдсэн санд явуулсан.</p>	
<p>3.2.1. Монгол Улсад түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллагад удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дангаар буюу хяналтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулна Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>ГИХГ-ын Зүүн бүс дэх газар нь тайлангийн хугацаанд бүсийн газрын дарга болон хяналтын улсын ахлах байцаагчийн баталсан №17/02-201832-17/02-201837 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 3, нийт 6 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтанд нийт 18 аж ахуй нэгжийн, гадаадын 259 иргэн хамрагдсан.</p>	

<p>3.2.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө өгч ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тайлангийн хугацаанд нийт 5 зөрчлийг илрүүлж, зөрчил гаргасан БНХАУ-ын 5 иргэнд нийт 360.000.00 /гурван зуун жаран мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч зөрчлийг шийдвэрлэсэн байна.</p>	
<p>3.2.3. Хууль, тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Тайлангийн хугацаанд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 4, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан БНХАУ-ийн 3 нийт 7-н иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.7 дахь хэсэг, 2010 оны Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7 дахь заалтад заасны дагуу 3 жилийн хугацаанд Монгол Улсад дахин орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргасан.</p>	
<p>3.2.4. “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр визийг хүчингүй болгоно Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Мөн Зүүн бүс дэх газраас алдаатай олгосон 7 визийг хүчингүй болгож /void/ тэмдгээр хүчингүй болгож 7 виз шинээр олгосон.</p>	
<p>3.2.5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, тогтоомжид заагдсан үндэслэлээр гадаадын иргэнийг Хил дээрээс буцаах арга хэмжээг журмын дагуу хэрэгжүүлж ажиллана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Сүмбэр боомтод хяналтын улсын байцаагч Б.Энхтулга нь орох чиглэлд БНХАУ-ын 15 иргэнийг Монгол улсад орох визгүй байсан тул ГИЭЗБТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтыг үндэслэн, Бичигт боомтод БНХАУ-н 2 иргэнийг ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалыг /Монгол Улсад байх буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй/ тус тус үндэслэн нийт 17-н иргэнийг хилээр нэвтрүүлэлгүй буцаасан байна.</p>	
<p>4.1.1 2018 оны Бүсийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт болон хүний нөөц, бусад шаардлагатай судалгаа мэдээллийг</p>	<p>Төвөөс ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу Тамгын газарт сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар 2018 оны ажлын төлөвлөгөөний 3 дугаар улирлын биелэлт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар улирлын биелэлт, албан</p>	

<p>гарган Тамгын газар, БОНХ-т хүргүүлэх, Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Дээд шатны байгууллага, албан тушаалтан хүссэн мэдээллээ авсан байна. Хугацаа: Сардаа</p>	<p>хаагч нарын ажлын байрны тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах санал, төрийн үйлчилгээний албан хаагч нарын 9 дүгээр сарын ур чадварын нэмэгдэл олгуулах санал, өргөдөл гомдлын мэдээний хамт, Боомт орон нутгийн хэлтэст хилийн бүсийн газрын 8 дүгээр сарын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, мөн сарын инфо мэдээ, Бүсийн даргын 9 дүгээр сарын төлөвлөгөөг тус тус гаргаж “и оффис” хаягаар хүргүүлсэн.</p>	
<p>5.1. Байгууллагын баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах, бүртгэлжүүлэх, сан үүсгэх Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Ирсэн бичиг: Гадаадын иргэн харьяатын газраас 3, бусад байгууллагаас 10 нийт 13 албан бичиг ирж, үүнээс хариутай 4 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэсэн. Явсан бичиг: Гадаадын иргэн, харьяатын газарт 9, албан хаагчдад 1, бусад байгууллагад 25 нийт 35 албан бичиг явуулж үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, албан бичгийн хариуг хүргэж ажилласан. Өргөдөл: Тус сард албан хаагчдаас болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандаж гаргасан өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт ирээгүй байна.</p>	
<p>6.1.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах. Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Зориулалтын дагуу зарцуулсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>2018 оны 9 дүгээр сард 40,939,400.00 төгрөгийн санхүүжилтийг авсан. Үүнээс 35,073,421.93 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн. 2018 оны 08 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 328,884,300.00 төгрөгийн санхүүжилт, 293,399,675.87 төгрөгийн гүйцэтгэлтэй, 35,484,624.13 төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.</p>	
<p>6.1.2. Тэмдэгтийн хураамжийн болон хүү, торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 08 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 14,354,500.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 3,640,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.</p>	

<p>6.2.1. Бүсийн төв болон бусад нэгж, техник хэрэгсэлд шаардлагатай бараа материал, эд зүйлээр нь хангаж ажиллах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Тооцоо судалгаа хийгдсэн байна Хугацаа: Сардаа. /тусгай арга хэмжээ/</p>	<p>“Техникийн комисс”-ын 04 дүгээр хурлыг хуралдаж бүсийн газрын төвд ашиглагдаж буй 65-99 ДОА улсын дугаартай “ТОЁОТА ПРИУС” автомашины амортизатор, пүрш, накладыг шинээр худалдан авч засварлахаар шийдвэрлэлээ. “Өмч хамгаалах зөвлөл” ийн 06 дугаар хурлыг хуралдаж Ульхан боомтын компьютерт эх хавтан худалдан авах талаар хэлэлцсэн. Бүсийн төвд ашиглагдаж байгаа 75-55 ДОА улсын дугаартай “Ниссан патрол” автомашинд албан хэрэгцээнд ашиглах зорилгоор GPS төхөөрөмжийг “Доктор Авто Сүлжээ” компаниас худалдан авсан. Эрэнцав боомтын 3 үйлдэлт принтерийн хор шинээр 1 ширхэг, 1 үйлдэлт принтерийн хор 1 ширхэг цэнэглүүлсэн.</p>	
<p>6.2.2. Хилийн боомт дахь албаны байрны өвөлжилтийн бэлтгэлийг хангалт, түлээ нүүрсний нийт өртөг тооцоог судалж гаргах Тоо хэмжээ: 1 удаа Чанар: Материалын тооцоо бодитой байна. Хугацаа: Сардаа. /Тусгай арга хэмжээ/</p>	<p>Бүсийн дарга, ахлах нягтлан нар Ульхан, Эрэнцав, Баянхошуу боомтуудад газар дээр нь очиж ажиллан Ульхан боомтод 20м3 мод, Эрэнцав боомтод эхний байдлаар 5 тонн нүүрс, Баянхошуу боомтод 30 тонн нүүрс шаардлагатайг тооцож гаргасан.</p>	
<p>7.1.1. “ISM” системийн сайжруулалт, хөгжүүлэлтийг тухай бүр гүйцэтгэж, албанд ашиглана Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Найдвартай системтэй байна Хугацаа: Жилдээ /тусгай арга хэмжээ/</p>	<p>08 дугаар сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 24-ны өдрийг дуустал Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж, ISM систем гарсан зөрчилгүй хэвийн ажилласан. Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Солонго, Хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаяр, Ц.Анхбаяр, мэргэжилтэн Г.Намуунзаяа нарын “ISM” програмын шилжүүлэх эрхийг бүртгэн авч, мэдээллийн технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн. Eset endpoint security антивирус програмыг хилийн боомтуудын нийт 10 компьютеруудад 09 дүгээр сарын шинэчлэлтийг хийж хортой кодоос урьдчилан сэргийлсэн. Хилийн боомтуудын Хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” програм болон компьютер техникийн 8 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.</p>	
<p>7.1.2. Албан үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютер, тоног төхөөрөмжийн урсгал</p>	<p>Бүсийн газрын харьяа Ульхан боомтод 09 дүгээр сарын 01-ны өдрийн 18-19 цагийн орчимд бороо орж албаны байрны урд талд ойрхон хүчтэй</p>	

<p>засвар үйлчилгээ, эвдрэл гэмтлийг тухай бүр засварлах Тоо хэмжээ: Тухай бүр Чанар: Үйл ажиллагааны тасралтгүй байдал хангагдсан байна Хугацаа: Сардаа</p>	<p>аянга буусны улмаас тус боомтын компьютер асахгүй эвдэрснийг бүсийн газарт авчруулан засварлаж хэвийн ажиллагаанд оруулан мэргэжилтэн Б.Оюунчимэгт хүлээлгэн өгсөн.</p> <p>Бүсийн газрын харьяа Хэнтий аймагт дотоод сүлжээний ISM, E-Office, спарк зэрэг програмууд ажиллахгүй болсон тул 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд ажиллаж шилэн кабелиг шалгаж медиа конвертор хэвийн бус ажиллахгүй байгааг оношилсон ба “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-аас медиа конвертор худалдан авч 09 дүгээр сарын 12-ны өдөр Хэнтий аймаг дахь “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-тай хамтран дотоод сүлжээг хэвийн ажиллагаанд оруулсан.</p>	
--	---	--

ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР